

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	14
3.Аудитын тайлан .....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	16
3.4. Материаллаг байдал .....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	18
Төсвийн төлөвлөлт .....	18
Төсвийн гүйцэтгэл.....	18
Нэмэлт санхүүжилт .....	19
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	20
Залруулсан алдаа.....	20
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	20
Аудитын зөвлөмж.....	21
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	21
4. Менежментийн захидал.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	28



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ”-ИЙН ЗАХИРАЛ  
Н.ЭРДЭНЭБЯАР ТАНАА

2024.02.25 № 07/588  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь тайлант онд 9 чиглэлийн дагуу 17 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөө 95.7 хувийн гүйцэтгэлтэй ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 747,347.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс 670,858.0 мянган төгрөгөөр давсан, бэлэн мөнгө болон хөрөнгийн үлдэгдэлд тооллого хийгээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан зэрэг нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй санхүүгийн

тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх”, “тасалбар болголт”, “үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Жижиг мөнгөн сангийн данснаас тогтоосон хязгаарыг давсан гүйлгээ хийж картын дансыг зориулалт бусаар ашигладаг байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн, зөв шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,775,001,443.34</b>	<b>4,093,008,245.51</b>	
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	<b>123,967.07</b>	
<b>311</b>	<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	00.00	<b>123,860.00</b>	
31110	Төгрөг	00.00	123,860.00	
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	<b>107.07</b>	
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	<b>107.07</b>	
31211	Төрийн сангийн харилцах	00.00	107.07	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>52,773,296.30</b>	<b>78,123,854.59</b>	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>52,773,296.30</b>	<b>78,123,854.59</b>	
3351	Байгууллагаас авах авлага	52,773,295.30	78,123,853.59	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	01.00	01.00	
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>12,415,781.00</b>	<b>22,689,489.50</b>	
34600	Урьдчилж гарсан зардал	12,415,781.00	22,689,489.50	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,709,812,366.04</b>	<b>3,992,070,934.35</b>	
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>3,246,372,959.70</b>	<b>3,145,811,183.91</b>	
35110	Тусгай зориулалттай материал	396,343,230.76	232,947,232.10	
35130	Эм боох материал	2,850,029,728.94	2,912,863,951.81	
35300	<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>367,452,778.82</b>	<b>741,821,074.60</b>	
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>95,986,627.52</b>	<b>104,438,675.84</b>	
35410	Бичиг хэргийн материал	10,365,057.11	16,747,952.63	
35420	Аж ахуйн материал	30,321,795.62	39,686,733.02	
35440	Түлш, шатах тослох материал	1,334,004.02	1,357,172.76	
35450	Барилгын засварын материал	4,448,669.05	5,146,400.05	
35460	Хүнсний материал	35,116,601.72	26,975,917.38	
35470	Бусад хангамжийн материал	14,400,500.00	14,524,500.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,454,378,954.66</b>	<b>9,988,355,689.33</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>11,454,378,954.66</b>	<b>9,988,355,689.33</b>	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>11,291,351,148.55</b>	<b>9,839,921,733.98</b>	
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,998,749,529.00	3,998,749,529.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	-183,683,715.64	-253,260,511.84	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77,507,000.00	115,407,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,507,000.00	-79,401,999.98	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,570,416,460.50	10,574,387,440.50	
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,937,373,051.43	-5,225,041,586.81	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,151,994,737.49	1,159,079,907.49	
39208	Хуримтлагдсан элэгдэл	-308,752,811.37	-449,998,044.38	
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,043,300.00	5,043,300.00	
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,043,300.00	-5,043,300.00	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>163,027,806.11</b>	<b>148,433,955.35</b>	
39301	Програм хангамж	80,392,055.00	80,392,055.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,725,488.89	-13,495,257.01	

39303	Бусад биет бус хөрөнгө	87,361,240.00	87,361,240.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-5,824,082.64
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>15,229,380,398.00</b>	<b>14,081,363,934.84</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,988,948.00</b>	<b>44,250,453.22</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,988,948.00	44,250,453.22
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,988,948.00	6,622,383.22
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	6,138,613.22
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,988,948.00	483,770.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,988,948.00	483,770.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>00.00</b>	<b>37,628,070.00</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	00.00	37,628,070.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,227,391,450.00</b>	<b>14,037,113,481.62</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	15,227,391,450.00	14,037,113,481.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>2,838,458,653.00</b>	<b>2,838,458,653.00</b>
51101	Өмч: - төрийн	2,838,458,653.00	2,838,458,653.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>11,802,387,100.90</b>	<b>10,612,109,132.52</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	11,802,387,100.90	11,802,387,100.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,190,277,968.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	586,545,696.10	586,545,696.10
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>15,229,380,398.00</b>	<b>14,081,363,934.84</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>7,964,621,049.73</b>	<b>6,342,314,879.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,848,428,449.73</b>	<b>318,365,603.57</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,752,564,688.69	275,804,095.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,750,554,288.69	270,804,095.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,401,363,468.00	4,895,690.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	193,627,920.69	210,354,735.57
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	155,562,900.00	55,553,670.00
120005	Түрээсийн орлого	2,010,400.00	-
120009	Бусад орлого	-	5,000,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,095,863,761.04</b>	<b>42,561,508.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	5,679,794.04	42,561,508.00
122002	Хандив тусламж /гадаад/	1,090,183,967.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,116,192,600.00</b>	<b>6,023,949,276.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,022,604,700.00	5,858,608,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,022,604,700.00	5,858,608,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	93,587,900.00	165,341,176.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,550,000.00	46,535,000.00
131104	Дээд шатны ТЗ-ийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны ТЗ-д хуваарилсан хөрөнгө	-	29,600,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,037,900.00	89,205,216.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,648,866,007.46</b>	<b>7,532,592,847.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,648,866,007.46</b>	<b>7,532,592,847.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,562,861,875.20	7,297,360,714.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	942,045,166.00	1,002,791,004.05
210101	Үндсэн цалин	916,863,618.00	643,344,496.05
210102	Нэмэгдэл	17,207,911.00	231,138,595.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,975,000.00	76,154,211.00
210104	Урамшуулал	2,998,637.00	52,153,702.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>121,952,950.20</b>	<b>167,699,460.15</b>
210201	Тэтгэврийн даатгал	94,763,752.20	103,325,545.15
210202	Тэтгэмжийн даатгал	11,429,549.10	24,413,915.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,183.80	17,982,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,221,699.10	1,998,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,599,766.00	19,980,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>146,547,361.48</b>	<b>151,565,060.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	131,478,535.00	138,549,742.12
210302	Түлш, халаалт	11,716,210.82	10,041,460.08
210303	Цэвэр, бохир ус	3,352,615.66	2,973,858.30
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,239,042.24</b>	<b>91,555,207.98</b>
210401	Бичиг хэрэг	8,115,023.90	18,524,395.98
210402	Тээвэр, шатахуун	7,709,777.47	8,937,496.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,698,042.71	1,890,300.00



210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,709,923.16	9,873,763.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,000.00	6,016,293.43
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,960,275.00	46,312,958.61
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,667,653,058.36</b>	<b>3,955,324,930.12</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,568,634,577.98	3,828,100,844.41
210502	Хоол, хүнс	99,018,480.38	123,530,585.71
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,693,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,461,716.08</b>	<b>127,187,359.50</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,743,978.38	74,250,790.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,189,400.00
210604	Урсгал засвар	28,717,737.70	51,747,169.50
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,394,000.00</b>	<b>19,929,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,394,000.00	19,929,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>35,813,820.00</b>	<b>68,951,677.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,758,000.00	59,214,077.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,365,000.00	2,475,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	784,532.00	851,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,200.00	396,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	89,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,777,288.00	5,926,100.00
210807	Газрын төлбөр	658,800.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,564,754,760.84</b>	<b>1,712,356,214.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,633,781.00	197,376,799.43
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,509,120,979.84	1,514,979,415.33
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>86,004,132.26</b>	<b>235,232,133.89</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,920,000.00</b>	<b>81,091,928.98</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	40,289,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,920,000.00	40,802,728.98
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>71,084,132.26</b>	<b>154,140,204.91</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,084,132.26	154,140,204.91
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>315,755,042.27</b>	<b>(1,190,277,968.38)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>315,755,042.27</b>	<b>(1,190,277,968.38)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>6,710,513,938.04</b>	<b>7,680,711,413.98</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,640,231,941.04</b>	<b>1,646,523,022.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,640,231,941.04	1,646,523,022.98
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,640,231,941.04</b>	<b>1,641,523,022.98</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,396,506,826.00	1,504,687,522.68
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	241,008,115.04	136,835,500.00
120005	Түрээсийн орлого	2,717,000.00	-
120009	Бусад орлого		5,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,070,281,997.00</b>	<b>6,034,188,391.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,022,604,700.00	5,858,608,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,022,604,700.00	5,858,608,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,677,297.00	175,580,291.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,550,000.00	46,535,000.00
131104	Дээд шатны ТЗ-ийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,758,400.00	29,600,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,368,897.00	99,444,331.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>6,711,349,028.04</b>	<b>7,680,587,446.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,711,349,028.04</b>	<b>7,680,587,446.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,609,879,643.78</b>	<b>7,431,347,226.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	952,650,433.00	998,999,400.00
210101	Үндсэн цалин	586,606,933.00	566,542,600.00
210102	Нэмэгдэл	232,774,800.00	272,400,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,075,000.00	75,075,000.00
210104	Урамшуулал	58,193,700.00	84,981,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>128,221,506.00</b>	<b>144,854,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,822,506.00	94,904,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,479,800.00	9,990,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,063,600.00	17,982,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,896,000.00	1,998,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,959,600.00	19,980,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>146,547,360.66</b>	<b>150,097,825.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	131,478,535.00	138,549,742.12
210302	Түлш, халаалт	11,716,210.00	8,574,225.08
210303	Цэвэр, бохир ус	3,352,615.66	2,973,858.30
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,200,869.42</b>	<b>40,822,350.00</b>
210401	Бичиг хэрэг	5,013,023.71	4,811,800.00
210402	Тээвэр, шатахуун	7,128,000.00	11,956,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,955,585.71	1,890,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,058,260.00	21,802,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,000.00	361,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,153,172,634.00</b>	<b>5,749,738,186.00</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,032,856,500.00	5,615,344,500.00
210502	Хоол, хүнс	116,256,634.00	130,619,286.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,059,500.00	3,774,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>55,354,987.70</b>	<b>157,145,060.50</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,162,580.00	99,845,470.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	648,000.00	1,336,500.00
210604	Урсгал засвар	34,544,407.70	55,963,090.50
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,394,000.00</b>	<b>19,929,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,394,000.00	19,929,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>50,037,320.00</b>	<b>81,164,323.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,158,000.00	61,493,193.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,365,000.00	2,475,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	784,532.00	851,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,200.00	396,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	89,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,030,288.00	6,037,100.00
210807	Газрын төлбөр	658,800.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,770,500.00	9,822,530.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>87,300,533.00</b>	<b>88,595,381.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,300,533.00	88,595,381.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>101,469,384.26</b>	<b>249,240,220.91</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>71,084,132.26</b>	<b>-</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	71,084,132.26	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,385,252.00</b>	<b>95,100,016.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		40,289,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,385,252.00	54,810,816.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>154,140,204.91</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		154,140,204.91
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(835,090.00)</b>	<b>123,967.07</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(835,090.00)</b>	<b>123,967.07</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>835,090.00</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>123,967.07</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	00.00
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,838,458,653.00</b>	<b>586,545,696.10</b>	<b>11,802,387,100.90</b>	15,227,391,450.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,838,458,653.00</b>	<b>586,545,696.10</b>	<b>11,802,387,100.90</b>	15,227,391,450.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,190,277,968.38)	-1,190,277,968.38
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,838,458,653.00</b>	<b>586,545,696.10</b>	<b>10,612,109,132.52</b>	14,037,113,481.62

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,380,781,800.00</b>	<b>7,360,359,967.70</b>	<b>(20,421,832.30)</b>	<b>99.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,380,781,800.00</b>	<b>7,360,359,967.70</b>	<b>(20,421,832.30)</b>	<b>99.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,329,525,500.00</b>	<b>7,318,770,767.70</b>	<b>(10,754,732.30)</b>	<b>99.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>998,999,400.00</b>	<b>998,999,400.00</b>	-	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	566,542,600.00	566,542,600.00	-	100.0
210102	Нэмэгдэл	272,400,500.00	272,400,500.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,075,000.00	75,075,000.00	-	100.0
210104	Урамшуулал	84,981,300.00	84,981,300.00	-	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>144,854,900.00</b>	<b>144,854,900.00</b>	-	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	94,904,900.00	94,904,900.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,990,000.00	9,990,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,982,000.00	17,982,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,998,000.00	1,998,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,980,000.00	19,980,000.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>153,707,200.00</b>	<b>150,097,825.20</b>	<b>(3,609,374.80)</b>	<b>97.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	138,663,000.00	138,549,742.12	(113,257.88)	99.9
210302	Түлш, халаалт	11,180,700.00	8,574,224.78	(2,606,475.22)	76.6
210303	Цэвэр, бохир ус	3,863,500.00	2,973,858.30	(889,641.70)	76.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,268,600.00</b>	<b>35,238,200.00</b>	<b>(30,400.00)</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	4,086,200.00	4,055,800.00	(30,400.00)	99.2
210402	Тээвэр, шатахуун	7,128,000.00	7,128,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,890,300.00	1,890,300.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,802,900.00	21,802,900.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	361,200.00	361,200.00	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,746,168,900.00</b>	<b>5,746,168,088.00</b>	<b>(812.00)</b>	<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,615,344,500.00	5,615,344,500.00	-	100.0
210502	Хоол, хүнс	127,050,000.00	127,049,188.00	(812.00)	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,774,400.00	3,774,400.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>123,132,500.00</b>	<b>121,625,060.50</b>	<b>(1,507,439.50)</b>	<b>98.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	90,212,500.00	88,708,470.00	(1,504,030.00)	98.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,336,500.00	1,336,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	31,583,500.00	31,580,090.50	(3,409.50)	99.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,420,000.00</b>	<b>51,800.00</b>	<b>(1,368,200.00)</b>	<b>3.6</b>
210702	Дотоод албан томилолт	1,420,000.00	51,800.00	(1,368,200.00)	3.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>80,494,000.00</b>	<b>76,266,593.00</b>	<b>(4,227,407.00)</b>	<b>94.7</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,883,700.00	56,535,193.00	(2,348,507.00)	96.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,475,000.00	2,475,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	851,400.00	851,400.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	396,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	89,100.00	89,100.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,037,100.00	6,037,100.00	-	100.0
210807	Газрын төлбөр	871,700.00	-	(871,700.00)	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,890,000.00	9,882,800.00	(1,007,200.00)	90.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>45,480,000.00</b>	<b>45,468,901.00</b>	<b>(11,099.00)</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,480,000.00	45,468,901.00	(11,099.00)	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,256,300.00</b>	<b>41,589,200.00</b>	<b>(9,667,100.00)</b>	<b>81.1</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,256,300.00</b>	<b>41,589,200.00</b>	<b>(9,667,100.00)</b>	<b>81.1</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,956,300.00	40,289,200.00	(9,667,100.00)	80.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	1,300,000.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,380,781,800.00</b>	<b>7,496,289,605.00</b>	<b>115,507,805.00</b>	<b>101.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,860,336,400.00</b>	<b>5,858,608,100.00</b>	<b>(1,728,300.00)</b>	<b>99.9</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,860,336,400.00	5,858,608,100.00	(1,728,300.00)	99.9
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,520,445,400.00</b>	<b>1,637,681,505.00</b>	<b>117,236,105.00</b>	<b>107.7</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,390,445,400.00	1,504,167,005.00	113,721,605.00	108.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000,000.00	133,514,500.00	3,514,500.00	102.7
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>123,967.07</b>	<b>123,967.07</b>	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>69</b>	<b>69</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>178,551,143.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>178,551,143.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>111,491,210.02</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
210101	Үндсэн цалин	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-
210201	Тэтгэврийн даатгал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	5,584,150.00
210401	Бичиг хэрэг	-	756,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,828,150.00
2105	Нормативт зардал	-	3,570,098.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	-	3,570,098.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	35,520,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	11,137,000.00
210604	Урсгал засвар	-	24,383,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	19,878,000.00
210702	Дотоод албан томилолт	-	19,878,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,958,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,958,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	41,980,962.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	41,980,962.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>67,059,933.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	48,510,816.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	48,510,816.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	18,549,117.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,549,117.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>178,276,291.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>178,276,291.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	46,535,000.00
131104	Дээд шатны ТЗ-ийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны ТЗ-д хуваарилсан хөрөнгө	-	29,600,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	102,140,331.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Дабль аксиом Аудит” ХХК-ийн чанарын менежер Ч.Оюунцэцэг хянаж, аудитор Д.Отгонжаргал, аудиторын туслах Б.Бат-Оргил, аудиторын туслах С.Одгэрэл нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 29-ний өдрийн 33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь улсын хэмжээнд цусны донор элсүүлэлт, цус авах, цус, цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, чанар аюулгүй байдал, цусны сонор сэрэмжийн тогтолцоо, цус сэлбэлт, судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах стандарт заавар, арга зүйн зөвлөмж боловсруулах, мэргэжлийн дүгнэлт гаргах, цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, сургах, судалгаа, шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага /тусгай мэргэжлийн төв/ байна.

##### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗОРИЛГО:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн зорилго нь чадварлаг баг, дэвшилтэт технологи, инновацад тулгуурлан, үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээг хангасан тусламж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цус, цусан бүтээгдэхүүнээр клиник болон нэгдсэн эмнэлгүүдийг хангах
- Улсын хэмжээнд цусны албаны бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламжийн тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль



- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай МУ-ын ЗГ-ын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 30 тоот тогтоол
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай МУ-ын ЗГ-ын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 114 тоот тогтоол

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус төв нь 2018 онд "Эвиденсе Аудит" ХХК-иар нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь боловсруулагдсан.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Эрүүл мэндийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагын 7,648,866.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 76,488.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,148,016.5 мянган төгрөгөөр буюу 7,5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	124.0	124.0
Авлага	52,773.3	78,123.9	25,350.6
Урьдчилгаа	12,415.8	22,689.5	10,273.7
Бараа материал	3,709,812.4	3,992,070.9	282,258.6
Үндсэн хөрөнгө	11,454,379.0	9,988,355.7	(1,466,023.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>15,229,380.4</b>	<b>14,081,363.9</b>	<b>(1,148,016.5)</b>
Өр төлбөр	1,988.9	44,250.5	<b>42,261.5</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,227,391.5	14,037,113.5	<b>(1,190,278.0)</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>15,229,380.4</b>	<b>14,081,363.9</b>	<b>(1,148,016.5)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 123.9 мянган төгрөг болж 123.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн шууд захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийг баримтлан ажиллаагүй байна.

Авлага дансны үлдэгдэл 78,129.9 мянган төгрөг болж 25,350.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2016-2020 онуудад үүссэн, насжилт өндөртэй 42,029.6 мянган төгрөгийн авлага байна.

Тайлант оны эцэст авлагын үлдэгдэлтэй үлдсэн 70 байгууллагаас 56 байгууллагын 59,400.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,992,070.9 мянган төгрөг болж 282,258.5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн материал өссөнөөс шалтгаалжээ. Тайлант жилийн эцэст бараа материалын тооллого хийсэн боловч, тооллогын үр дүнг тооцож, өмч хамгаалах комиссоор тооллогын ажлын үр дүнг хэлэлцэж шийдвэрлээгүй байна.

Бараа материалын дансанд хөрөнгө оруулалтаар бэлтгэн харьяа байгууллагууд болон захиалагч байгууллагад шилжүүлээгүй бүртгэлтэй хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,988,355.6 мянган төгрөг болж 1,466,023.3 мянган төгрөгөөр буурсан нь материаллаг хэмжээний үндсэн хөрөнгө худалдан аваагүй тул хуримтлагдсан элэгдлээр буурсан байна. Үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгө оруулалт, урсгал төсвийн хөрөнгөөр хийсэн худалдан авалт байхгүй, харин хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 44,639.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Тайлант оны эцэст үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй, өмнөх аудитаар 710,153.0 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн жагсаалт гаргаж, хөрөнгийн үнэ, ашиглагдах жилийг шинэчлэн тогтоох зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй байна. Үндсэн хөрөнгөнөөс үнэ төлбөргүй бусдад шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй.

Тайлант онд биет бус хөрөнгө худалдан аваагүй тул хуримтлагдсан элэгдлээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 44,250.4 мянган төгрөг болж 42,261.5 мянган төгрөгөөр өссөн нь Цэргийн төв эмнэлэг нь цус худалдан авах гэрээний дагуу төлбөрөө төлсөн боловч тус эмнэлэг нь бүтээгдэхүүн хадгалах сав, агуулахын боломжгүй шалтгаанаар бүтээгдэхүүнээ аваагүйн улмаас 37,628.1 мянган, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт хугацаандаа төлөгдөөгүйгээс ажилчидтай холбогдсон өглөг данс 6,138.6 мянган төгрөгийн өглөг үүссэн нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,037,113.5 мянган төгрөг болж 1,190,277.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал шалтгаалжээ.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,622,306.2 мянган төгрөгөөр буюу 20.3 хувиар буурсан нь тайлант оны үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг орлогоор бүртгэж тайлагналгүй авлагын дансаар бүртгэсэн нь нөлөөлсөн байна

Нийт зардал өмнөх оноос 116,273.2 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин 6.4 хувиар, үүнээс нэмэгдэл цалин өмнөх оноос 13.4 дахин өссөн байна. Унаа хоолны хөнгөлөлт 15.3 дахин, урамшуулал 17.4 дахин өссөн байна. Энэ нь 2020 онд урамшуулал болон бусад нэмэгдэл цалинг хавтгайруулан олгосонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 22,361,047.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 22,361,047.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14,498,266.1 мянган төгрөгөөр бууруулж 7,390,836.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрийн 282 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,380,781.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 5,860,336.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 1,520,445.4 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,858,608.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,637,681.5 мянган төгрөг, нийт 7,496,289.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 7,360,359.9 мянган төгрөгийг зарцуулж 135,929.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,360,369.9 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,609.4 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 4,227.4 мянган, эд хогшил,

урсгал засварын зардал 1,507.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 29,600.9 мянган, хандив тусламж 46,535.0 мянган, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 102,140.3 мянган, нийт 178,276.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ДЭМБ-ын санхүүжилтийн 7,260.0 мянган төгрөгийг дэлхийн донорын өдөрт, 39,275.0 мянган төгрөгийг донорын сургалт сурталчилгаанд, Эрүүл мэндийг дэмжих сангийн 29,600.9 мянган төгрөгийг донорын сургалт сурталчилгаанд, ОБЕГ-ын санхүүжилтийн 3,120.0 мянган төгрөгийг гамшгийн хангалтын төлбөрт, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос үр дүнгийн урамшуулалд 34,502.7 мянган, ахмадын хүндэтгэлд 5,000.0 мянган, нийгмийн даатгалын шимтгэлд 4,934.4 мянган, ХХОАТ 4,073.6 мянган, халуун хөшиг авахад 21,263.0 мянган, MSC аппаратын сэлбэгт 11,137.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулагдаагүй үлдсэн 18,549.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шинэлэн дансанд байршуулбал зохих 146 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 121 мэдээлэл, хугацаа нь болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 22 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 711,592.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж, 15,469.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн боловч биелэлт хангалтгүй 50.0 хувьтай, тайлант онд албан шаардлага өгсөн алдаа зөрчил давтан гарсан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /Мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	15,469.4	1	12,672.4	1	2,797.0	50.0
Зөвлөмж	4	711,592.2	2	317.2	2	711,275.0	50.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>727,061.6</b>	<b>3</b>	<b>12,989.6</b>	<b>3</b>	<b>714,072.0</b>	<b>50.0</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,708,668.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 961,321.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 57,128.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 690,218.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Туслах үйл ажиллагаанаас олсон 352,786.1 мянган төгрөгийн орлогыг үндсэн хөрөнгө борлуулснаас олсон орлогоор бүртгэж тайлагнасныг залруулав.
2. Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 586,545.7 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тусгаагүйг тодруулга тайланд тусгуулсан
3. Цалингийн урьдчилгаа 71.5 мянган төгрөгийг шууд зардлын дансанд бүртгэснийг залруулав
4. Аж ахуйн, бичиг хэргийн материалын 21,918.2 мянган төгрөгийн материалын зарцуулалтыг эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлын дансанд бүртгэснийг залруулав

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 747,347.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 57,128.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал нь дээд шатны эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө 1,018.3 (Нэг сая арван найман мянга гурван зуун) мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал, мөн байгууллагын үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос нэр бүхий 64 ажилтанд 43,510.8 (Дөчин гурван мянга таван зуун арван мянга найман зуун) мянган төгрөгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Жижиг мөнгөн сангийн данснаас тогтоосон хязгаарыг давсан гүйлгээ хийж картын дансыг зориулалт бусаар ашигладаг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалын 7.13-д “*Төсвийн байгууллага төрийн сангаас гадуур банкинд харилцах данс нээсэн, картын дансыг зориулалт бусаар ашигласан, кассаар хийгдэх ажил гүйлгээг, жижиг мөнгөн сангийн үлдэгдлийг байвал зохих хэмжээнээс нь хэтрүүлсэн нь нотлогдвол тухайн төсвийн байгууллагад төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах эрх олгохгүй*”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “*Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

#### **Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жижиг мөнгөн санд тушаасан үйл ажиллагааны мөнгөн орлогыг өдөрт нь төрийн санд төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд бэлэн мөнгөний үлдэгдэлд

тооллого хийгээгүй, биет тест хэрэгжүүлэхэд 12,723.5 (Арван хоёр сая долоон зуун хорин гурван мянга таван зуун) мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассдаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана", санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "оршин байх", "эрх үүрэг" батламж мэдэгдэлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

### **Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 690,218.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 13 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь үндсэн үйл ажиллагааны орлогыг авлагын дансаар бүртгэсэн, хөрөнгө бараа материалын үлдэгдлийг тооллого хийж тооцооны үр дүнг тайлагнаагүй, картын данс болон урьдчилж гарсан зардлын дансаар жижиг мөнгөн сангийн хязгаараас давсан бэлэн мөнгөний ажил гүйлгээ хийгддэг тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Мэдээлэл технологийн хэлтэс нь 2021 онд Эрүүл хүүхэд, эрүүл шүд аян, Гемодиализын үйлчилгээг үзүүлж буй Эрүүл мэндийн байгууллагуудад хуруу уншигч төхөөрөмж суурилуулж даатгуулагчийн авч буй үйлчилгээний тоо, төлбөрийн хэмжээг хянах боломжийг бүрдүүлсэн байна. Эрүүл мэндийн яамнаас санхүүжигдэж буй дээрх төрлийн үйлчилгээний санхүүжилт мэдээлэл технологийн төвийн мэдээллийн сан дахь бүртгэлийн мэдээллийн дагуу байгаа эсэх нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хас банк дахь картын харилцах данснаас бэлнээр болон картаар бэлэн авсан 52,716.0 мянган төгрөгийг кассын нярваар /ЖМС/ дамжуулалгүй, анхан шатны баримт үйлдэлгүйгээр шууд урьдчилж гаргасан зардлын дансанд бүртгэж зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчиж, иж бүрэн байх, оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт сулрах, хөрөнгө үрэгдэх, шамшигдах, зориулалт бусаар зарцуулагдах, хууль тогтоомж зөрчигдөх

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 276 тушаалын 1 дүгээр хавсралтыг мөрдөж ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

##### 2. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: И баримтад 67 байгууллагын 822,473.8 мянган төгрөгийн баримтыг дутуу оруулсан, 52 байгууллагын 20,148.4 мянган төгрөгийн баримт илүү оруулсан байгаа нь татварын цахим системд шивэгдсэн НХМаягт ТМ-5 төлбөрийн баримтгүй бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Эрсдэл: Худалдаж авч байгаа бараа, ажил, үйлчилгээ буюу байгууллагаас гарч байгаа зардалд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сулрах, ажил гүйлгээний дүн анхан шатны баримтын дүнгээс зөрүүтэй байх.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны үнэн зөв баримтад /цахим И баримт/ үндэслэн төлбөрийг шилжүүлж байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3. Балансын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант оны эцэст хөрөнгийн тооллогыг хийсэн гэх боловч тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй, тооллогын үр дүнг Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчиж, оршин байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Эрсдэл:** Хөрөнгөнд тавих дотоод хяналт сулрах, хөрөнгө үрэгдэх, дутагдах, хэрэгцээ чанарын шаардлагагүй хангахгүй илүүдэл хөрөнгө бий болох

**Өгсөн зөвлөмж:** Улирал, жилийн эцэст тооллогыг тогтмол хийж, тооцоог бодолтыг хийж, Өмч хамгаалах комиссын хурлаар үр дүнг хэлэлцэн шийдвэрлэж байх

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **4. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Шилэн дансанд байгууллагын ерөнхий нягтлан бодогчийн мэдээллийг өөрчлөөгүй, шилэн дансанд байршуулсан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг 231,006.9 мянган, зарлагын мөнгөн гүйлгээ 57,400 мянган төгрөгөөр тус тус дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т "Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна", 5 дугаар зүйлийн 5.5-т "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Эрсдэл:** Шилэн дансны тухай хуулийг мөрдөхгүй, мэдээллийн нээлттэй, ил тод байх зарчим хэрэгжүүлэхгүй байх

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтад үндэслэн мэдээллийг үнэн зөв, заасан хугацаанд нь байршуулж мэдээлэх

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **5. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

**Илрүүлэлт:** Тайлант онд захиалагчийн худалдан авах ажиллагааны ерөнхий шаардлагад тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй "Өлзий хишиг гранд" ХХК-тай 31,900.0 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээг шууд байгуулсан, "Илдэнгүн хошуу ХХК-д 6,203.4 мянган төгрөгийг гэрээний дүнгээс зөрүүтэй шилжүүлсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т "Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт



нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчиж, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналт сулрах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихгүй байх.

Өгсөн зөвлөмж: Цаашид хууль тогтоомжид заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулан дүгнэж байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **6. Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд 70 байгууллагаас 78,673.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гэж тайлагнасны 56 байгууллагын 59,428.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Дотоод хяналт сулрах, тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө үрэгдэх, эзэнгүйдэх

Өгсөн зөвлөмж: Улирал жилийн эцэст харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг актаар баталгаажуулж хэвших.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **7. Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Урьдчилж гаргасан зардал дансны эхний үлдэгдэл 12,415.8 мянган төгрөг нь тайлант оны эхэнд кассад бэлнээр байсан нь биет тест хэрэгжүүлэх явцад нотлогдсон бөгөөд 2020 оны эхний хагас жилд зарцуулагдсаныг бүртгэлд тусгаж тайлагнаагүй, мөн онд картын данснаас авсан бэлэн мөнгийг ЖМС-д орлого авалгүйгээр анхан шатны баримт үйлдэлгүй урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэн, доноруудад мөнгөн урамшуулал, ахмад ажилчдад хүндэтгэл үзүүлэхэд зориулан ЖМС-ийн хязгаарыг баримтлалгүй 43,970.5 мянган төгрөгийг шууд зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", "13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчиж, иж бүрэн байх, оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт сулрах, тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө үрэгдэх, шамшигдах

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 276 тушаалын 1 дүгээр хавсралтыг мөрдөж ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **8. Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Цар тахлын үед дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө, бараа материалыг санхүүгийн тайланд тусгахдаа цаад хандивлагч байгууллагын баримтыг бүрэн гүйцэд авч, тайланд хавсаргаагүй, зарим материалыг үнэгүй тоо ширхгээр нь орлогод авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх" мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг зөрчиж, оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө үнэгүйдэх, үрэгдэх, шамшигдах

Өгсөн зөвлөмж: Дээд байгууллагын шийдвэрийг мөрдөж ажиллах

Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **9. Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан бараа материал, үзүүлсэн ажил үйлчилгээний 173,165.6 мянган төгрөгийн төлбөрийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллаагүй, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Бүртгэлээр тавих хяналт суларч, тайлан буруу илэрхийлэгдэж, санхүүгийн мэдээлэл хэрэглэгчид болон харилцагчдыг буруу мэдээллээр хангах

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөж ажиллах.

Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **10. Цалин хөлсний данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Цалинг дахин тооцоолж, Нийгмийн даатгал, Хувь хүний орлогын албан татварын тайлантай тулгалт хийн үзэхэд цалингийн санг 4,828.8 мянган, НДШ-ийг 1,225.5 мянган, ХХОАТ-ыг 3,205.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь энэ хуулийн 16.1-д "заасан этгээдийн шаардсан тайлбар, тодруулгыг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгнө" 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг баримтлаагүй, үнэн зөв байдал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Бүртгэлээр тавих хяналт сул, санхүүгийн мэдээлэл хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах, хууль тогтоомж зөрчигдөх

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтаа сайжруулж, хууль тогтоомжийг баримтлан ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **11. Цалин хөлсний данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Хууль эрх зүйн үндэслэлийг буруу тогтоосон захирлын 2020 оны А/25 дугаар тушаалаар 7,027.9 мянган төгрөгийн, мөн уг тушаалд тусгагдаагүй албан тушаалтанд 2,232.2 мянган төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно", Сангийн сайдын 2006 оны 292 тоот тушаалын 1.1-д "Төрийн өмчит аж ахуйн нэгж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж, шагнаж урамшуулахад энэ журмыг мөрдлөг болгоно", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын 5.1-д "Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь чанартай, бүрэн гаргаж, өр авлагагүй ажилласан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн өмчит ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам"-ын дагуу шагнаж урамшуулна" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Эрсдэл:** Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, тушаал шийдвэрийг үндэслэлгүй гаргах, ажлын үр дүн, чиг үүргийг харгалзахгүй урамшууллыг хавтгайруулан олгох

**Өгсөн зөвлөмж:** Цаашид хууль, тогтоомж, шийдвэрийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **12. Цалин хөлсний данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Захирлын 2020 оны А/32 тоот тушаалыг үндэслэн санхүүгийн ажилтнууд олгохоор шийдвэрлэсэн балансын урамшуулал 3,208.1 мянган төгрөгөөс 1,116.1 мянган төгрөгийг өөр чиг үүргийн албан тушаалтанд олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно", Сангийн сайдын 2006 оны 292 тоот тушаалын 1.1-д "Төрийн өмчит аж ахуйн нэгж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж, шагнаж урамшуулахад энэ журмыг мөрдлөг болгоно", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын 5.1-д "Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь чанартай, бүрэн гаргаж, өр авлагагүй ажилласан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн өмчит ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам"-ын дагуу шагнаж урамшуулна" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, тушаал шийдвэрийг үндэслэлгүй гаргах, ажлын үр дүн, чиг үүргийг харгалзахгүй урамшууллыг хавтгайруулан олгох

Өгсөн зөвлөмж: Цаашид хууль, тогтоомж, шийдвэрийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **13. Цалин хөлсний данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Захирлын 2020 оны А/59 тоот тушаалын дагуу коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг тогтвортой хангах чиглэлээр шинэ санал санаачилга гаргаж идэвхтэй ажилласан ажилтнуудыг мөнгөн шагналаар шагнахдаа шагналыг хавтгайруулан нийт 52 ажилтанд 14,975.7 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчиж, үнэн зөв байдал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, шагнал урамшууллыг хавтгайруулан олгох

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжийг баримтлан ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021 он			САГ-2021/64/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цус сэлбэлт судлалын үндэсний төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жижиг мөнгөн санд тушаасан үйл ажиллагааны мөнгөн орлогыг өдөрт нь төрийн санд төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд бэлэн мөнгөний үлдэгдэлд тооллого хийгээгүй, биет тест хэрэгжүүлэхэд 12,723.5 (Арван хоёр сая долоон зуун хорин гурван мянга таван зуун) мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнаагүй	12,599.4	Албан шаардлага	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
2	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал нь дээд шатны эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө 1,018.3 (Нэг сая арван найман мянга гурван зуун) мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал, мөн байгууллагын үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос нэр бүхий 64 ажилтанд 43,510.8 (Дөчин гурван мянга таван зуун арван мянга найман зуун) мянган төгрөгийн урамшууллыг тус тус олгосон. Жижиг мөнгөн сангийн данснаас тогтоосон хязгаарыг давсан гүйлгээ хийж картын дансыг зориулалт бусаар ашигладаг.	44,529.1	Албан шаардлага	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
3	Хас банк дахь картын харилцах данснаас бэлнээр болон картаар бэлэн авсан 52,716.0 мянган төгрөгийг кассын нярваар /ЖМС/ дамжуулалгүй, анхан шатны баримт үйлдэлгүйгээр шууд урьдчилж гаргасан зардлын дансанд бүртгэж зарцуулсан байна.	52,716.0	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул

4	И баримтад 67 байгууллагын 822,473.8 мянган төгрөгийн баримтыг дутуу оруулсан, 52 байгууллагын 20,148.4 мянган төгрөгийн баримт илүү оруулсан байгаа нь татварын цахим системд шивэгдсэн НХМаягт ТМ-5 төлбөрийн баримтгүй бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн		Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
5	Тайлант оны эцэст хөрөнгийн тооллогыг хийсэн гэх боловч тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй, тооллогын үр дүнг Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэж, тайлагнаагүй.		Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
6	Шилэн дансанд байгууллагын ерөнхий нягтлан бодогчийн мэдээллийг өөрчлөөгүй, шилэн дансанд байршуулсан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг 231,006.9 мянган, зарлагын мөнгөн гүйлгээ 57,400 мянган төгрөгөөр тус тус дутуу мэдээлсэн.	288,406.9	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
7	Хууль эрх зүйн үндэслэлийг буруу тогтоосон захирлын 2020 оны А/25 дугаар тушаалаар 7,027.9 мянган төгрөгийн, мөн уг тушаалд тусгагдаагүй албан тушаалтанд 2,232.2 мянган төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.	9,260.1	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
8	Захирлын 2020 оны А/32 тоот тушаалыг үндэслэн санхүүгийн ажилтнууд олгохоор шийдвэрлэсэн балансын урамшуулал 3,208.1 мянган төгрөгөөс 1,116.1 мянган төгрөгийг өөр чиг үүргийн албан тушаалтанд олгосон	1,116.1	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
9	Захирлын 2020 оны А/59 тоот тушаалын дагуу коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг тогтвортой хангах чиглэлээр шинэ санал санаачилга гаргаж идэвхтэй ажилласан ажилтнуудыг мөнгөн шагналаар шагнахдаа шагналыг хавтгайруулан нийт 52 ажилтанд 14,975.7 мянган төгрөгийг олгосон.	14,975.7	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
10	Цалинг дахин тооцоолж, Нийгмийн даатгал, Хувь хүний орлогын албан татварын тайлантай тулгалт хийн үзэхэд цалингийн санг 4,828.8 мянган, НДШ-ийг 1,225.5 мянган, ХХОАТ-ыг 3,205.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан	9,259.8	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул

11	Тайлант онд захиалагчийн худалдан авах ажиллагааны ерөнхий шаардлагад тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй "Өлзий хишиг гранд" ХХК-тай 31,900.0 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээг шууд байгуулсан, "Илдэнгүн хошуу ХХК-д 6,203.4 мянган төгрөгийг гэрээний дүнгээс зөрүүтэй шилжүүлсэн	38,103.4	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
12	Санхүүгийн тайланд 70 байгууллагаас 78,673.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гэж тайлагнасны 56 байгууллагын 59,428.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй	59,428.0	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
13	Урьдчилж гаргасан зардал дансны эхний үлдэгдэл 12,415.8 мянган төгрөг нь тайлант оны эхэнд кассад бэлнээр байсан нь биет тест хэрэгжүүлэх явцад нотлогдсон бөгөөд 2020 оны эхний хагас жилд зарцуулагдсаныг бүртгэлд тусгаж тайлагнаагүй, мөн онд картын данснаас авсан бэлэн мөнгийг ЖМС-д орлого авалгүйгээр анхан шатны баримт үйлдэлгүй урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэн, доноруудад мөнгөн урамшуулал, ахмад ажилчдад хүндэтгэл үзүүлэхэд зориулан ЖМС-ийн хязгаарыг баримтлалгүй 43,970.5 мянган төгрөгийг шууд зарцуулсан	56,386.3	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
14	Цар тахлын үед дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө, бараа материалыг санхүүгийн тайланд тусгахдаа цаад хандивлагч байгууллагын баримтыг бүрэн гүйцэд авч, тайланд хавсаргаагүй, зарим материалыг үнэгүй тоо ширхгээр нь орлогод авсан		Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
15	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан бараа материал, үзүүлсэн ажил үйлчилгээний 173,165.6 мянган төгрөгийн төлбөрийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн	173,165.6	Зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагч, Нягтлан бодогч	Н.Эрдэнэбаяр, Б.Өнөрзул
<b>ДҮН</b>		<b>747,347.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 217/АО170074  
САГ- 2021/64/СТА-ТМЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал нь дээд шатны эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө 1,018.3 (Нэг сая арван найман мянга гурван зуун) мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал, мөн байгууллагын үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос нэр бүхий 64 ажилтанд 43,510.8 (Дөчин гурван мянга таван зуун арван мянга найман зуун) мянган төгрөгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Жижиг мөнгөн сангийн данснаас тогтоосон хязгаарыг давсан гүйлгээ хийж картын дансыг зориулалт бусаар ашигладаг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалын 7.13-д "Төсвийн байгууллага төрийн сангаас гадуур банкинд харилцах данс нээсэн, картын дансыг зориулалт бусаар ашигласан, кассаар хийгдэх ажил гүйлгээг, жижиг мөнгөн сангийн үлдэгдлийг байвал зохих хэмжээнээс нь хэтрүүлсэн нь нотлогдвол тухайн төсвийн байгууллагад төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах эрх олгохгүй", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12.1-д "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв захирагч нь төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, алдаа зөрчлийг таслан зогсоон албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, ерөнхий нягтлан бодогч Б.Өнөрзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Г.МӨНХЧИМЭГ  
Т.МЯГМАРСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 218/А0170074  
САН-2021/64/СТА-ТЦЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жижиг мөнгөн санд тушаасан үйл ажиллагааны мөнгөн орлогыг ажлын дараагийн өдөрт нь багтаан төрийн санд төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд бэлэн мөнгөний үлдэгдэлд тооллого хийгээгүй, биет тест хэрэгжүүлэхэд 12,723.5 (Арван хоёр сая долоон зуун хорин гурван мянга таван зуун) мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассдаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана", санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "оршин байх", "эрх үүрэг" батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийг мөрдөж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, ерөнхий нягтлан бодогч Б.Өнөрзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Ф.МӨНХЧИМЭГ  
Т.МЯГМАРСҮРЭН



